

БАТЛАВ.  
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГА | Л.БЯМБАСҮРЭН

2020 оны 06 дугаар сарын 02 ны өдөр

НИСЭХИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН АЛБАНЫ  
ӨВЛИЙН ГАДУУР ХУВЦАС, ХАВАР НАМРЫН ГАДУУР ХУВЦАС, ЗУНЫ  
ХӨДӨЛМӨР ХАМГААЛЛЫН ГУТАЛ, ХУВЦАСНЫ ТЕХНИКИЙН  
ТОДОРХОЙЛОЛТ

## 1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Энэхүү техникийн тодорхойлолтод нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны ажилтнуудын өвлийн нэхий дээл, хавар намрын гадуур хувцас, ажлын тусгай гутал, зуны хөдөлмөр хамгааллын хувцас нийлүүлэх техникийн тодорхойлолтыг тусгасан болно.

## 2. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

2.1. Өвлийн нэхий дээл, хавар намрын гадуур хувцас, ажлын тусгай гутал, зуны хөдөлмөр хамгааллын хувцас нь ажилтны бие мах бодийг үйлдвэрлэлийн хортой болон аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах зориулалт бүхий Монгол Улсын стандарт MNS 0637:1992, MNS ISO 13688:2000, MNS 2217:2011 зөвлөмжүүдийн шаардлагад бүрэн нийцсэн байна.

2.2. Өвлийн нэхий дээл, хавар намрын гадуур хувцас, ажлын тусгай гутал, зуны хөдөлмөр хамгааллын хувцас нь техникийн үзүүлэлт хэсэгт болон хавсралт зурагт заасан шаардлагыг бүрэн хангасан байх шаардлагатай бөгөөд дараах баримт бичгийг хавсарган ирүүлнэ. Үүнд:

2.2.1. Үйлдвэрлэгчийн гарал үүслийн гэрчилгээ.

2.2.2. Баталгаат хугацааг тодорхойлсон гэрчилгээ.

2.3. Захиалагчийн товлосон өдөр гүйцэтгэгч нь гутал, хувцасны хэмжээг авах ажлыг зохион байгуулна.

## 3. БАТАЛГААТ ХУГАЦАА

3.1. Захиалагч тал ажил хүлээн авах актад гарын үсэг зурж, хүлээн авснаас хойш 6 сараас доошгүй байна.

## 4. ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

4.1. Өвлийн нэхий дээл (Зураг - 1)

№	Үзүүлэлт	Шаардлага
1	Материал	MNS 0637:1992 стандартын дагуу хонины нэхийг боловсруулан хийсэн илгэн нэхий

2	Өнгө	Гадна загварын үндсэн өнгө: Хар
3	Загвар	Монгол улсын стандарт MNS 2217: 2011 4.2 заалтын дагуу 76-аас 95 см урттай классик загвартай дунд дээл, энгэртээ 4ш товчтой, хажуу талын гадна халаас ташуу байрлалтай 2ш, дотор энгэрийн халаас 1ш
4	Эрүүл ахуй	Хувцас хийх нэхийний үсэн бүрхүүлийн өндөр нь хүний биед сөрөг нөлөө үзүүлэхгүй, дулааны тааламжтай байдлыг хангахуйц хэмжээнд тайрсан байна.  Нэхий хувцасны хэлбэр, бүрдэл хэсгүүдийн хэмжээг тухайн хувцасны зориулалтыг харгалзан дулаанаа алдахгүй, хүний биеийн хэсгүүдийг хүйтнээс хамгаалж байхаар хийсэн байна.
5	Эргономик	Нэхий дээл нь өмсөхөд биед эвтэй, суулт тохироо сайтай, хүний хөдөлгөөнд саад болохгүй, халаас, товчлоос болон бусад элементүүд нь ашиглахад тохиромжтой, жин багатай байвал зохино.  Тайван хөдөлгөөнгүй зогсох үед хувцасны гадаргуу дээр нэг үрчлээс хуниасгүй толигор байхаар зохион бүтээлийг зөв хийсэн байна.  Хөдөлгөөнд саадгүй байхын тулд сулын тавилтыг зөв сонгосон, ар энгэр, суганы ухлаадасны өргөнд оновчтой хуваарилсан байна.
6	Эдэлгээ	Нэхий дээл нь бөх бат, мөрний хатуулга болон наалт сайн байх, хэлбэрээ хадгалах чадвар сайтай байна.

#### 4.2 Хавар намрын гадуур хувцас (Цув) (Зураг - 2)

№	Үзүүлэлт	Шаардлага
1	Материал	100 % полиэстер,
2	Өнгө	Гадна загварын үндсэн өнгө: Хар хөх
3	Загвар	76-аас 95 см урттай, классик загвартай, дотор талын энгэртээ цахилгаантай мөн 4ш далд товчтой, хажуу талын гадна халаас 20см гүнтэй, ташуу байрлалтай 2ш, дотор энгэрийн халаас 1ш
4	Дотор материал	Хувцасны дотор материал хүний биед сөрөг нөлөө үзүүлэхгүй, дулааны тааламжтай байдлыг хангахуйц хэмжээнд байна.
5	Эргономик	Гадуур цув нь өмсөхөд биед эвтэй, суулт тохироо сайтай, хүний хөдөлгөөнд саад болохгүй, халаас, товчлоос болон бусад элементүүд нь ашиглахад тохиромжтой, жин багатай байвал зохино.  Тайван хөдөлгөөнгүй зогсох үед хувцасны гадаргуу дээр нэг үрчлээс хуниасгүй толигор байхаар зохион бүтээлийг зөв хийсэн байна.  Хөдөлгөөнд саадгүй байхын тулд сулын тавилтыг зөв сонгосон, ар энгэр, суганы ухлаадасны өргөнд оновчтой хуваарилсан байна.

#### 4.3 Зуны гутал (Зураг – 3, 4)

№	Үзүүлэлт	Шаардлага
---	----------	-----------

1	Материал	Бүрэн боловсруулсан сайн чанарын ус нэвчдэггүй 2,1 мм зузаантай арьсан материалтай байна. Өсгийн сайжруулсан хамгаалалт нь элэгдлийн эсрэг хамгаалалттай байх ба үрэлт зүсэлтийн нөлөөг бууруулдаг байна.
2	Түрий	Хагас түрийтэй байна.
3	Өнгө	Хар
4	Стандарт	EN ISO 20345:2007 S3 CI SRC евро стандартын шаардлага хангасан байна.
5	Доторлогоо	Хөлний амьсгалах чадварыг нэмэгдүүлж, хөлсийг түргэн шингээх, хатаах зориулалттай байна. Гутлын түрий хэсэг болон хэл нь хөлийг тав тухтай, тогтвортой байх зорилгоор зөөлөвч хийгдсэн байна.
6	Ул	- Элэгдэлд тэсвэртэй гулгалтын эсрэг 2D цутгамал ултай, бензин, тос, хүчилд тэсвэртэй байна. - Хатгалтаас хамгаалсан дунд ул нь металл бус нэхмэл утастай - Хөлд эвтэйхэн нумтай, статик цахилгаан дамжуулахгүй, хөлний анатомийн бүтцэд нийцсэн, хөнгөн, уян чанартай байна.
7	Хурууны хамгаалалт	-200 джоулийн механик үйлчлэлээс хамгаалах хөнгөн, металл хамгаалалттай байна.

#### 4.4 Зуны хүрэм (Зураг - 5)

№	Үзүүлэлт	Шаардлага
1	Материал	35% полиестер, 65% хөвөн даавуун материалтай цахилгаан дамжуулдаггүй, хүний биед сөрөг нөлөөгүй, чийгний хамгаалалттай, бохирдол татдаггүй гадна материалтай байна.
2	Өнгө	Гадна загварын үндсэн өнгө: Шаргал
3	Зах	Хүзүү холгохооргүй, зөөлөн даавуун 8-10 см өргөнтэй, нугалж өмсөх зориулалттай байна.
4	Хормой	Хүрэмний доод хэсгээр резинтэй, доод хэсэгтээ кноптой байна.
5	Халаас	Гадна талд энгэрийн баруун, зүүн талд 14 см өргөн, 16 см өндөр хэмжээтэй 2ш цахилгаантай халаас байна. Халаас нь далд байрлах ба босоо чиглэлтэй цахилгаантай байна. Хажуу талын гадна халаас ташуу байрлалтай 2ш халаас байна. Далд байрлалтай, цахилгаантай байна.
6	Бичилт, Ялгах тэмдэг	Зүүн энгэрт Иргэний нисэхийн ерөнхий газрын бэлгэдэл (Зураг - 6). Бэлэгдлийн урт 9 см, өндөр 4 см, өнгө шар, бөмбөрцгийн өнгө нь цэнхэр байна. Aviation safety inspection /зүүн энгэрт жижгээр, ар нуруунд томоор/
7	Ханцуй	Ханцуйн монтаж нь ихэсгэж богиносгох зориулалттай наалттай, монтажны өргөн 5 см байна.

4.5 Зуны өмд (Зураг - 5)

№	Үзүүлэлт	Шаардлага
1	Материал	35% полиэстер, 65% хөвөн даавуун материалтай, цахилгаан дамжуулдаггүй, хүний биед сөрөг нөлөөгүй гадна материалтай байна.
2	Өнгө	Гадна загварын үндсэн өнгө: Шаргал
3	Халаас	2 ташаанд ташуу чиглэлтэй 20 см гүн цахилгаантай халаас байна.
5	Мөрөвч	Өөрийн биеийн хэмжээнд тааруулж байхаар тохируулагчтай байна.

5. НИЙЛҮҮЛЭЛТ

5.1. Нийлүүлэгч тал нь энэхүү Техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасан хамгаалах гутал, хувцсыг гэрээ байгуулсан өдрөөс 2 сарын дотор нийлүүлнэ.

Нийлүүлэх хувцасны тоо хэмжээ

№	Өвлийн нэхий дээл	Хавар намрын гадуур хувцас (цув)	Хөдөлмөр хамгааллын зуны гутал	Хөдөлмөр хамгааллын Зуны хувцас /хос/
нийт тоо ширхэг	<b>21 ширхэг</b> (Эрэгтэй)	<b>31 ширхэг</b> (Эрэгтэй 21 ш, Эмэгтэй 10 ш)	<b>31 ширхэг</b> (Эрэгтэй 21 ш, Эмэгтэй 10 ш)	<b>31 ширхэг</b> (Эрэгтэй 21 ш, Эмэгтэй 10 ш)

6. ХҮЛЭЭН АВАХ

6.1. Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын тушаалаар томилогдсон ажил хүлээн авах комисс хамгаалах гутал, хувцсыг техникийн тодорхойлолтын үзүүлэлт, тодорхойлолтын дагуу шалган хүлээн авч акт үйлдсэнээр барааг хүлээн авсанд тооцно.

ХЯНАСАН:

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДЭД ДАРГА

Б.АЛТАНЦОМ

БОЛОВСРУУЛСАН:

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДАРГА

С.ЕРХАНАТ

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ГИШҮҮН

Б.ХАТАНБҮҮВЭЙБААТАР

Г.ЦОЛМОН

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Г.ОЮУНБОЛД

Б.МӨНХБААТАР

(Зургууд)

Зураг-1



Зураг-2



Зураг-3



Зураг-4



Зураг-5



Зураг-6

